



СЭРГЭЭН ЗАСАЛ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан тасралтгүй сургалтаас сүүлийн 5 жилийн хугацаанд 10-аас доошгүй багц цаг бүрдүүлсэн байх;
2. Бие Бялдар Сэргээн Засах Судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хэвлүүлсэн бүтээлийн хураангуй, эсвэл судалгааны илтгэлийн тоо 5-аас доошгүй байх /Үүний бүтээлийн хураангуйд судалгааны өгүүллээс гадна мэргэжлийн холбогдолтой зөвлөмж, гарын авлагыг оруулж тооцож болно, илтгэл бол 3 нь заавал ББСЗСМН-ийн Эрдмийн чуулганд аман болон ханын илтгэлээр хэлэлцүүлсэн байна/;
3. Бие Бялдар Сэргээн Засах мэргэшлийн чиглэлийн зонхилон тохиолдох 8 бүлэг өвчлөлөөс өөрөө бие дааж сэргээн засах эмчилгээ хийсэн 30 тохиолдлын талаар шалгуурт өгөгдсөн загварын дагуу тэмдэглэл хөтөлсөн байх (хүснэгт А, Б).

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан тасралтгүй сургалтаас сүүлийн 5 жилийн хугацаанд 15-аас доошгүй багц цаг бүрдүүлсэн байх;
2. Бие Бялдар Сэргээн Засах Судлалын чиглэлээр сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ судалгааны хэвлүүлсэн бүтээлийн хураангуй, эсвэл судалгааны илтгэлийн тоо 8-аас доошгүй байх /Үүний бүтээлийн хураангуйд судалгааны өгүүллээс гадна мэргэжлийн холбогдолтой зөвлөмж, гарын авлагыг оруулж тооцож болно, илтгэл бол 5 нь заавал ББСЗСМН-ийн Эрдмийн чуулганд аман болон ханын илтгэлээр хэлэлцүүлсэн байна/;
3. Бие Бялдар Сэргээн Засах мэргэшлийн чиглэлийн зонхилон тохиолдох 8 бүлэг өвчлөлөөс өөрөө бие дааж сэргээн засах эмчилгээ хийсэн 50

тохиолдлын талаар шалгуурт өгөгдсөн загварын дагуу тэмдэглэл хөтөлсөн байх (хүснэгт А, Б);

4. Бие Бялдар Сэргээн Засах мэргэшлийн чиглэлээр сүүлийн 5 жилийн хугацаанд 5-аас доошгүй удаа ажлын байрны болон мэргэшил дээшлүүлэх сургалт удирдсан, заасан туршлагатай байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх сургалтаас сүүлийн 5 жилийн хугацаанд 20-иос доошгүй багц цаг бүрдүүлсэн байх;
2. Бие Бялдар Сэргээн Засах Судлалын чиглэлээр сүүлийн 5 жилийн хугацаанд 10-аас доошгүй эрдэм шинжилгээ судалгааны хураангуй хэвлүүлсэн байх /үүний 4 хүртэлх бүтээлийг нь мэргэжлийн холбогдолтой зөвлөмж, гарын авлагын тоогоор тооцуулж болно/;
3. Бие Бялдар Сэргээн Засах Судлалын чиглэлээр сүүлийн 5 жилийн хугацаанд 15-оос доошгүй судалгааны илтгэл хэлэлцүүлсэн байх /Үүний 7 хүртэлх илтгэл нь судалгааны бус холбогдох мэргэжлийн чиглэлээр нийгэмлэг холбооны эрдэм шинжилгээний хурал, семинар, симпозиумд тусгай болон боловсролын илтгэлээр хэлэлцүүлсэн байж болно/;
4. Бие Бялдар Сэргээн Засах мэргэшлийн чиглэлийн зонхилон тохиолдох 8 бүлэг өвчлөлөөс өөрөө бие дааж сэргээн засах эмчилгээ хийсэн 100 тохиолдлын талаар шалгуурт өгөгдсөн загварын дагуу тэмдэглэл хөтөлсөн байх (хүснэгт А, Б);
5. Бие Бялдар Сэргээн Засах мэргэшлийн чиглэлээр сүүлийн 5 жилийн хугацаанд 5- аас доошгүй удаа ажлын байрны болон мэргэжил дээшлүүлэх сургалт удирдсан, заасан туршлагатай байх.

